



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/309

Номгон

Согтууруулах ундаагаар үйлчлэх
тусгай зөвшөөрөл олгох тухай

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.4, 16 дугаар зүйлийн 16.2, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 5.3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу Жаргалант сумын “Уянга хийморь өргөө” ХХК-ний Уянга караокены тусгай зөвшөөрлийн хугацааг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 2029 оны 05 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаагаар шинээр олгосугай.

2. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, шийдвэр, цагийн хуваарийг чанд мөрдөж, иргэдэд стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн худалдаалахыг аж ахуйн нэгжийн захирал (Л.Өлзийжаргал)-д, холбогдох хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаад хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

624010747